



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 2/30

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/431 дүгээр захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/431 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдан төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (Х.Энхбаатар)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга захиалагчийн хэлтэс (Б.Ганзориг)-т даалгасугай.

4.Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 05 дугаар сарын 15-ны
өдрийн 21/30 дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Х.ЭНХБААТАР

(НХОГ-ын Барилга
захиалагчийн хэлтсийн
Барилгын хяналтын инженер)

ГИШҮҮД:

Б.ЗУЛЦЭЦЭГ

(НЗДТГ-ын Хууль, эрх зүйн
хэлтсийн Эрх зүйн сургалт,
сурталчилгаа, хүний эрх,
нийгмийн салбарын асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Т.УНДАРМАА

(НХОГ-ын Төлөвлөлт судалгааны
хэлтсийн Төлөвлөлт
судалгааны мэргэжилтэн)

Ч.НЯМДАВАА

(Хан-Уул дүүргийн 2 дугаар
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Г.БАТ-ЭРДЭНЭ

(НХОГ-ын Барилга
захиалагчийн хэлтсийн
Ус хангамж, ариутгах
татуургын хяналтын инженер)